



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/186

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын Байтаг багийн нутаг “Цагаан толгой” гэх газарт хяналтын цэг байгуулан ажиллаж байгаа үүрэг гүйцэтгэгч нарын зардалд 5000,0 мянган /Таван сая/ төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээний 5000,0 мянган төгрөг /Таван сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 дугаар хуралдааны 5/07 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.2 дахь заалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагын газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа (Ц.Булганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дүгээр сарын 05-ны өдрийн
А/186 дугаар захирамжийн хавсралт

БУЛГАН СУМЫН БАЙТАГ БАГИЙН НУТАГ “ЦАГААН ТОЛГОЙ”
ПОСТОД ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

/ төгрөгөөр/

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун	литр	1260 л	2 885	3 635 100
2	Алба хаагч үүрэг гүйцэтгэхэд гарах зардал	1 хоногт	97	14 000	1 364 900
НИЙТ					5 000 000

-оОо-